



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 07 өдөр

Дугаар А/53

Арвайхээр сум

Салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг  
шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн “Өвөрхангай аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 03/03 тогтоолоор батлагдсан Өвөрхангай аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.6.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Мэргэжлийн боловсрол, сургалтын үндэсний зөвлөлийн Өвөрхангай аймаг дахь салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн, хавсралтаар баталсугай.

2.Салбар зөвлөлийн үйл ажиллагааг удирдлага зохион байгуулалтаар ханган, жил бүр төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллахыг салбар зөвлөлийн дарга (Б.Сайнжаргал)-д үүрэг болгосугай.

3.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын “Салбар зөвлөлийн бүрэлдэхүүн” шинэчлэн батлах тухай” 2021 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн А/66 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6223 11 0106

Аймгийн Засаг даргын 2023 оны  
... дугаар сарын ... ны өдрийн  
... дугаар захирамжийн  
хавсралт



**МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН ҮНДЭСНИЙ  
ЗӨВЛӨЛИЙН ОРОН НУТАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН  
БҮРЭЛДЭХҮҮН**

Салбар зөвлөлийн дарга: Б.Сайнжаргал (аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)

Гишүүд:

Ц.Ариунаа (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Хүнс, хөдөө аж ахуйн газрын үйлдвэр худалдаа үйлчилгээний албаны дарга)

С.Даваасүрэн (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын хэлтсийн дарга)

Б.Мөнгөншагай (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Боловсрол шинжлэх ухааны газрын мэргэжилтэн)

Б.Даваадавга (Онги, Ус суваг орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын ерөнхий инженер)

Ё.Цэцэгээ (Өгөөмөр рашаан сувиллын захирал)

Ц.Мөнхдэлгэр (Хангамж-Өргөө ХХК-ний үйлдвэрийн дарга)

Б.Мөнхбайгаль (Топ зүү ХХК-ийн захирал)

Нарийн бичгийн дарга:

С.Санчир (Өвөрхангай аймаг дахь Политехник коллежийн захирал)

-оОо-